



**ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО,
ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН
ТОГТООЛ**

2023 оны 05 сарын 02 өдөр

Дугаар 162

Улаанбаатар хот

**Орон сууц хувьчлах товчоо байгуулах
тухай**

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 9, Орон сууц хувьчлах тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 2 дахь хэсэг, Орон сууц хувьчлах товчооны ажиллах журмын 1.4 дэх заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Өвөрхангай аймгийн орон сууц хувьчлах товчоог хавсралтад заасан бүрэлдэхүүнтэй байгуулсугай.
2. Орон сууц хувьчлах тухай хууль тогтоомж, “Орон сууц хувьчлах товчооны ажиллах журам”-ыг мөрдөж ажиллахыг товчоонд үүрэг болгосугай.
3. Товчооны үйл ажиллагааны зардлыг зохих журмын дагуу тооцож, төсөвт тусган санхүүжүүлэхийг Өвөрхангай аймгийн Засаг дарга А.Ишдоржид зөвлөсүгэй.
4. Энэхүү тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн удирдлага, зохицуулалтын хэлтэс (Ц.Баяр-Эрдэнэ)-т даалгасугай.


ДАРГА

Б.ЦЭНГЭЛ

ТӨРИЙН ӨМЧИЙН УДИРДЛАГА,
ЗОХИЦУУЛАЛТЫН ХЭЛТСИЙН
ДАРГА

Ц.БАЯР-ЭРДЭНЭ

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын
газрын 2023 оны 05 дугаар сарын 02-ны
едрийн 162 тогтоолын хавсралт



ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН ОРОН СУУЦ ХУВЬЧЛАХ
ТОВЧООНЫ БҮРЭЛДЭХҮҮН

Товчооны дарга

Аймгийн Засаг даргын эрхлэх
асуудлын хүрээний агентлаг Орон
нутгийн өмчийн газрын дарга

Нарийн бичгийн дарга

Аймгийн Засаг даргын эрхлэх
асуудлын хүрээний агентлаг Орон
нутгийн өмчийн газрын ахлах
мэргэжилтэн

Гишүүд

Аймгийн Засаг даргын Тамгын
газрын Санхүү, төрийн сангийн
хэлтсийн дарга/

Аймгийн Засаг даргын Тамгын
газрын Хууль, эрхзүйн хэлтсийн
ахлах мэргэжилтэн

Аймгийн Засаг даргын Тамгын
газрын Хөгжлийн бодлого,
төлөвлөлт, хөрөнгө оруулалтын
хэлтсийн ахлах мэргэжилтэн/